

# **НИЙГМИЙН ИННОВАЦИ**

## **ТАМХИНЫ ЭРСДЭЛТ ЗАН ҮЙЛ ХИЙГЭЭД ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ИННОВАЦИЙН САНАА**

*Ц. Батцэрэн Доктор (Ph. D.), профессор  
Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль  
tseren\_mn@must.edu.mn*

*Хураангуй: Монгол Улс 2005 онд тамхины эсрэг хуультай болж, 2012 онд Тамхины хяналтын тухай хуулийг шинэчилж баталсан байдаг. Тамхины хяналтын тухай хуулийг засгийн газар, мэргэжлийн хяналтын байгууллага болон цагдаагийн байгууллага, аж ахун нэгж байгууллага хяналт тавин ажиллах үүрэгтэй. Мөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон төрийн бус байгууллага, иргэ хяналт тавих эрхтэй юм. Уг хууль хэрэгжиснээс хойш нилээд хэдэн жил болж байгаа бөгөөд уг хуулийн хэрэгжилт, үр дүнг тодруулахыг зорьсон болно. Тамхины эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд “Тамхины хяналтын тухай хууль”-ийн нөлөө, түүний хэрэгжилтийн талаар 150 иргэдээс санал асуулга авч анализ хийсэн болно.*

*Түлхүүр үгс: тамхи, эрсдэлт зан үйл, хэрэглээ, хууль, хэрэгжилт,*

### **I. УДИРТГАЛ ХЭСЭГ**

Орчин үеийн экзистенциалист философид хүн бүр өөрөө өрийнхөө өмнө хариуцлага хүлээдэг гэж үздэг. Тийм учраас Сартр “Би бол миний сонголт юм” гэж хэлсэн байдаг. Ардчилсан нийгэм нь өгөгдсөн өргөн боломжоос чөлөөт зөв сонголт хийж, өөрийнхөө төлөө хариуцлага хүлээх чадвар бүхий бие хүнийг үндсэн загвараа болгож байна. Утга төгөлдөр сайхан амьдралыг хүний оршин тогтохуйн үндсэн асуудалтай нягт холбодог. Сайхан амьдралын үндэс эрүүл мэнд гэдгийг хүн бүр мэдэх ч, эрүүл мэндийг нөхцөлдүүлэгч хүчин зүйлс болох хөдөлгөөн, хооллолт, ажил амралтын дэглэм, хорт зуршил зэрэг амьдралын буруу хэв маяг болсон зүйлд тэр бүр ач холбогдол өгөлгүй байна. Гэтэл амьдралын буруу хэв маягаас үүдэлтэй өвчлөлүүдийн тоо нэмэгдсээр. Өнөөгийн дэлхийн анагаах ухааны чиг хандлага бол өвчилсөн хойно эмчлэх бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин хүндрэхээс сэргийлэх, олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох, өвчин үүсэхэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйл, шалтгааныг арилгахад чиглэж байна.

Өвчин үүсгэх анхдагч шалтгаан нь өвчин үүсгэгч нян, эмгэг төрөгч бие гэж үздэг байсан бол харин одоо хүний өөрийнх нь амьдралын хэв маяг хамгийн ихээр нөлөөлж байна гэж үзэх болжээ. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болоод буй халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл нь зан үйл болон бодисын солилцоо гэсэн үндсэн хоёр бүлэгт хуваагддаг (ДЭМБ, 2018). Зан үйлийн шинжтэй буюу хувь хүнээс шалтгаалсан эрсдэлт хүчин зүйлсэд эрүүл бус, зохисгүй хооллолт, архи, тамхины хэрэглээ[10] болон хөдөлгөөний идэвхгүй байдал орно. Тухайлбал өвчний шалтгаан:

- 51.2%-ийг амьдралын хэв маяг эрүүл аж төрөх ёстой холбоотой
- 20.4%-ийг удамшил, биологийн чанаруудтай
- 19.9%-ийг хүрээлэн буй орчны нөлөөтэй
- 8.5%-ийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрэлцээ, хангамжтай холбоотой гэж эрдэмтэд тус тус тооцоолсон байна.

Хүний эрүүл мэндэд биологийн төдийгүй нийгэм, эдийн засаг, улс төрийн гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлдгөөс гадна эцсийн дүнд эрүүл мэндээ хайрлан хамгаалах талаар хувь хүний өөрийнх нь мэдлэг, боловсрол, зан үйл, хандлагаас хамгийн их нөлөөлөлтэй байна. Ийм учраас хүнийг өөрийг хөгжүүлэх замаар эрүүл мэндийг хамгаалан сайжруулах нь хамгийн чухал.

## **II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ**

Олон ийтийн оролцоотойгоор асуудлыг хөндөж, олон нийтийн дэмжлэг туслалцааг өргөжүүлэх замаар олон нийтийг идэвхижүүлэх нь хүн амын бүхий л давхаргыг хамарч эрүүл мэнд болон нийгмийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй, өртөг зардал бага шаардах арга юм. Бид хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчилхөд нөлөөлж, эрсдэлт зан үйл, дадлыг нь өөрчилснөөр маш олон өвчлөл, осол гэмтэлээс сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалахад нь туслаж чадна.

Зан үйл гэдэг нь хэвшил, зуршлын нөлөөгөөр илрэн гардаг эерэг, сөрөг үр дагавар бүхий дахин давтагддаг хүний үйлдэл юм. Өөрөөр хэлбэл хувь хүний хэвшил, зуршил болсон үйлдлүүд юм. Зан үйлийг дотор нь эерэг ба сөрөг гэж 2 ангилан үздэг. Эерэг зан үйл гэдэг нь өөрт тустай, дадал зуршил болсон аливаа үйлдлүүд бол, сөрөг буюу эрсдэлт зан үйл нь нийгмийн амьдралд төдийгүй эрүүл мэндийн хувьд сөрөг үр дагавартай аливаа үйлдлүүд орно. Хүн аливаа нэг үйлдлийг удаа дараа давтамжтай хийсний дүнд хэвшил, зуршил бий болно. Нэгэнт бий болсон хэвшил, зуршил нь тухайн үйлдлийг байнга давтан хийх өдөөгч, нөхцөл нь болдог. Жишээ нь: тамхи татах хүсэл төрж түүнд уриалан дуудаж байгаа нь зуршил юм.

Ихэнх улс оронд зан үйлийн эрсдэлтэй байдал нь өвчлөл, тахир дутуу, нас баралтын шалтгаан болж байна. Жишээлбэл: Тамхи нь зүрх судасны өвчин, уушиг, ам, умайн хүзүүний хорт хавдар, цус харвалт, уушигны архаг өвчлөл зэргийн шалтгаан болдог.

Тамхины хэрэглээ нь халдварт бус өвчин тэр дундаа хоёрдогч хэлбэрийн чихрийн шижин өвчин үүсэхэд тамхи таталт нь эрсдэлт хүчин зүйлсийн 5-рт ордог. Дэлхийн нийт хүн амын насанд хүрсэн эрэгтэйчүүдийн гуравны нэг нь тамхи татдаг бөгөөд тамхи таталттай холбоотой өвчнөөр жилд 10 хүн тутмын 1 буюу 4 сая хүн нас барж байна. Тамхи таталтын тархалт нь хөгжиж буй орнуудад ихэсч, харин өндөр хөгжилтэй орнуудад буурч байна. Тамхины эрүүл мэнд болон нийгэмд үзүүлэх хор хөнөөл нь Монгол улсад улам бүр нэмэгдсээр байгаа ба тус улсын эрэгтэйчүүдийн 68,5 хувь, эмэгтэйчүүдийн 30,4 хувь нь тамхи татдаг байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Тамхины хяналтын суурь конвенц 2005 онд хүчин төгөлдөр[3] болж үйлчилснээс хойш дэлхий дахинд тамхины хяналтын үйл ажиллагаанд ахиц дэвшил гарсан байна. Хөгжил бурай орнуудын хувьд тамхины хэрэглээ өндөр үзүүлэлттэй байгаа бөгөөд тус орнуудын засгийн газрууд тамхины хяналтыг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх засаглалын байгууллагад тодорхой хэм хэмжээ тогтоох эрхээ хуульд заан доош шилжүүлдэг (Delegative power) бол иргэд хуулийн төсөл боловсруулах явцад өөрсдийн эвлэлдэн нэгдсэн төрийн бус байгууллагаараа дамжуулан/ итгэмжлэн өөрсдийн эрхийг хамгаалах буюу саналаа тусгуулдаг итгэмжлэлийн ардчилал (Delegative democracy) нь дээшээ чиглэснээрээ ялгаатай ойлголт юм.

Судалгаанаас харахад нийтийн албаны зардал, татвар өндөр орнуудад төлөөллийн ардчилал илүү хөгжсөн байх бол харин шууд ардчилал хөгжсөн улс орнуудад энэхүү үзүүлэлт бууралттай байдаг байна.

Шууд ардчиллын үр дүнд ард нийт нь төрийнхөө үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байх, чинээлэг цөөнхийн гэхээсээ илүү олон нийтийн эрх ашигт нийцсэн хууль батлагдах гэх мэт олон давуу тал байх боловч төрийн тогтвортой бодлого баримтлах чадвар алдагдах, шийдвэр гаргах зардал өсөх, популист удирдагчдын үйл ажиллагаа идэвхижсэний үндсэн дээр санал өгөгч иргэд төөрөгдөлд автах гэх мэт сул талууд үүсдэг.

Хуулийн төсөлд олон нийтээс санал авах нь эцсийн шийдвэрийг батлах эрх биш хэдий ч шууд ардчиллын шинж чанарыг агуулж байгаа үйл ажиллагаа мөн.

Шууд ардчиллын олон аргууд байдаг. Үүнээс дурдаж болох онцлог арга бол орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан олон нийтийн оролцоог

хангах арга юм. Хамтарсан цахим ардчилал нь оролцогч иргэн бүр шууд, эсхүл шууд бусаар прокси төлөөллийг ашиглан өөр өөр бодлогын салбарын тодорхой асуудалд санал өгөх замаар оролцох боломж юм. Энэ аргыг анх 2009 онд судлаач Петрик Клаус танилцуулсан юм. Мөн Ann Seidman болон Robert B. Seidman нар батлагдан гарсан хуулиуд олон нийтийн эрх ашигт бүрэн нийцсэн байж чадахгүй байгаагийн учир шалтгааныг судлаад "...“ардчилал” гэдэг нэр томъёог дан ганц өрсөлдөөнтэй сонгууль гэж тодорхойлох нь хангалтгүй. ...Хүмүүс төвтэй хөгжлийн талаарх популист мөрөөдлийн бүтэлгүйтлийг тайлбарлахын тулд хууль тогтоох процессыг судлаад зогсохгүй, ихэвчлэн хүнд сурталтай, нууцлалын ард явагддаг хуулийн төсөл боловсруулах үйл явцыг судлах шаардлагатай [11] гэж үзсэн байдаг.

Тохиромжтой хууль тогтоох онолын дагуу судалгааны тайланг хуулийн төслийн хамт гаргахыг шаардсан дүрэм журам баталснаар хоёр үр дагавар үүснэ. Нэгдүгээрт, хуулийн төсөл нь түүнийг бэхжүүлэх судалгааны чанар дээр суурилж байгаа тул хуулийн төслийн чанар сайжрах магадлалтай. Судалгааны тайлангийн агуулгыг тодорхой болгосноор эрх баригчид хуулийн төсөл боловсруулагч нь хуулийн төсөл нь

1. Шийдвэрлэхээр зорьж буй асуудал бүхий хандлагын шалтгааныг хангалттай тусгасан,

2. Эдгээр шалтгаануудыг даван гарах хувилбар бүхий шийдлүүдийг санал болгосон,

3. Санал болгож буй шийдлүүдээс зардал болон үр ашгийг харьцуулсны үндсэн дээр сонголт хийсэн байгаа эсэхийг баталгаажуулахын тулд хийгдэх шаардлагатай судалгааг нарийвчлан тодорхойлж чадна. Эрх зүйн актын төсөл боловсруулснаар хуулийн төсөл боловсруулагчид хуулийн төслөө туршлага дээр суурилан боловсруулах илүү магадлалтай болно. Уг судалгааны тайлан нь хуулийн төслийн гол чанарын хяналтыг бий болгоно.

Хоёрдугаарт, хуулийн төслийг ямар ч сайд, кабинет, парламентын гишүүн өнгөн талаас нь үнэлэх боломжгүй. Хуулийг боловсруулах, хэрэгжүүлэхэд үйл явцыг хангах шинэ дүрэм журмууд шаардлагатай[11] байдаг.

Тамхидалт эрсдэлт зан үйл хэдий ч төрөөс зөв бодлого баримтлан зохистой хууль, дүрмийг батлаж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотой үр өгөөжийг сурталчлан таниулж, зохих арга хэмжээг авч чадвал буруулах боломжтойг олон улсын туршлагаас харж болно.

### III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Тамхидалт түүний хор уршиг, тамхины хяналтын тухай хуулийн талаар 150 хүнээс санал асуулгыг санамсаргүй түүврийн аргаар авч, гарсан үр дүнд анализ хийлээ. Уг санал асуулганд 18-29 насны 44 хүн, 30-39 насны 28 хүн, 40-49 насны 28 хүн, 50-59 насны 32 хүн, 60-аас дээш насны 19 хүнээс 72 эрэгтэй, 78 эмэгтэй оролцов.


График 1. Насны бүтэц



Судалгаанд оролцогчдоос 42 хүн тамхи татдаг, 13 хүн нь тамхинаас гарсан, хааяа татдаг 16 хүн, огт татдаггүй 79 хүн гэж хариулсан байна.


Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал нь үзэхэд бага боловсролтой 1,3%, бүрэн бус дунд 14.7%, бүрэн дунд 24%, тусгай дунд 16.7%, дээд боловсролтой 43.3% , нийт оролцогчдын хөдөлмөр эрхлэлт өндөр буюу 47 %-тай байв.

График 2. Ажил, хөдөлмөр эрхлэлт




Судалгаанд хамрагдсан хүмүүсээс тамхины хамааралын талаар тодруулахад 52,6 хувь нь татдаггүй, 28 хувь нь татдаг, 8,6 хувь гарсан, 10,6 хувь нь хааяа татдаг гэсэн хариултыг өгчээ.

График 3. Тамхины хамаарал




Тамхи татсан хугацаанаас харахад 60,8 хувь нь 5 буюу түүнээс дээш жил татсан байна. Үүнээс үзэхэд тамхи татах нь нэг төрлийн донтолт гэдгийг харуулна.

График 4. Тамхи татсан хугацаагаар авч үзвэл:



Тамхи татдаг хүмүүсээс Та тамхинаас гарахыг хүсдэг үү? гэсэн асуултанд 23 хүн тийм, 9 хүн заримдаа, 8 хүн үгүй гэж хариулсан байна.

График 5. Тамхинаас гарахыг хүсдэг үү? асуултанд хариулсан нь:



Мөн тамхинаас гарахад чинь илүүтэй нөлөө үзүүлэх хүчин зүйл юу вэ? асуултанд хууль, дүрэм гэсэн 34.4% , орчны нөлөө 12.5%, мөнгө санхүү 21.9% гэж хариулснаас харахад эрсдэлт зан үйлийг өөрчилөхөд гадаад хүчин зүйлийн нөлөө их болох нь харуулж байна.

График 6. Тамхинаас гарахад нөлөөлөх хүчин зүйлс нь:




Тамхины хор уршгийн дугаарлана уу гэсэн асуултын хариуг хариулсан байдлаар эрэмбэлэн үзвэл:

1. Эрүүл мэнд
2. Мөнгө санхүү
3. Орчны бохирдол
4. Цаг хугацаа загвар давамгайлж байлаа.

Тамхидалт нь эрсдэлт зан үйлийн нэг хэлбэр мөн үү? Асуултанд нийт оролцогчдын 69 буюу 46% мөн, 34(23%) нь биш, 47(31%) нь мэдэхгүй гэж хариулснаас үзэхэд иргэдийн дунд тамхины талаархи эрүүл мэндийн мэдлэг хангалтгүй байна.


График 7. Тамхидалт нь эрсдэлт зан үйл гэж үзэж буй, эсэх:



Тамхины хяналтын тухай хууль 2012 оны арваннэгдүгээр сард батлагдаж, 2013 оны гуравдугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулийн талаар та ямар бодолтой байна вэ? асуултанд нийт оролцогчдын

29.9% маш сайн, 32% сайн, 25% хэрэггүй, 14% нь мэдэхгүй хариултыг өгсөн байна.

График 8. Тамхины хяналтын тухай хуулийн ач холбогдолд өгсөн иргэдийн үнэлгээ:



Харин энэ хуулийн хэрэгжилтийн талаар санал асуулганд оролцогчдын 51% нь муу, 20.7% дунд, 6,3% сайн, 22% нь мэдэхгүй гэж хариулснаас үзэхэд иргэд уг хуулийг зөв зүйтэй хууль гэж үзэж байгаа хэдий ч уг хуулийн хэрэгжилтийг хангалтгүй гэж үзэж байна.

График 9. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэнд өгсөн үнэлгээ:



## IV. ДҮГНЭЛТ

Хүн бие хүн болж төлөвших явцдаа өөрийн гэсэн үнэлэмжийн системийн бүрдүүлж жинхэнэ “Би”-г бүтээж байдаг. Ингэж хөгжиж төлөвших явцдаа олон талт харилцаанд орж тэндээс өөрт таалагдаж таашаагдах гоо зүйн үнэлэмж, бусад зүйлстэй харилцах ёс зүйн хэм хэмжээний цогц, түүнийг илэрхийлэх зан үйлийн системийг бүрдүүлж байдаг. Энэхүү зан үйлийн систем нь хүний итгэл үнэмшил, мэдлэг чадвартай уяалдаатай, амьдралын явцад үүсдэг. Эдгээр үйлдлүүд нь ухамсартай болон ухамсаргүйгээр хийгддэг байна.

Иймд хуучин зан үйлийн өөрчилж шинэ зан үйл төлөвших процесс нь тодорхой цаг хугацаа болон хувь хүнээс ихээхэн хүч чармайлтыг шаарддаг. Тамхидалт нь эрсдэлт зан үйлийн нэг хэлбэрт зүй ёсоор ордог. Тамхины эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд гадаад хүчин зүйлсийн нөлөө их тухайлбал хууль, дүрэм, орчны нөлөө, мөнгө санхүү зэрэг хүчин зүйлийн нөлөө их болох нь харагдаж байна. Дээрхи санал асуулгаас харахад “Тамхины хяналтын тухай хууль”-ийг нийт оролцогчдын 61 хувь (91 хүн) нь зөв зүйтэй хууль хэмээн үнэлж байгаа хэдий ч уг хуулийн хэрэгжилтийн талаар сэтгэл хангалуун бус байна.

Иймд Монголд тамхигүй эрүүл орчныг бий болгох, тамхины эрсдэлт зан үйлийг өөрчлөхтэй холбоотой дараахи зүйлийг санал болгож байна. Үүнд:

1. Тамхины хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хорооны цагдаагын хэлтсүүд сайн дурын ажилтанг сурган хамтран ажиллах. Уг ажилтан Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж, уг хуулийн зүйл заалтын зөрчсөн этгээдэд торгууль тавих, албан байгууллагад санамж бичиг өгөх ба тухайн хороо, дүүргийн харьяалагдах эрх бүхий байгууллагад хандсанаар үйл ажиллагааг нь зогсоох эрх бүхий байх. Хуулийг хэрэгжүүлэхэд явцад оруулсанд орлогоос хувь тооцон цалинжихаар гэрээг байгуулж болох юм.
2. Судалгаанд оролцогчдын 21.9 хувь нь мөнгө, санхүүгийн асуудал нь тамхинаас гарахад нөлөөлөх шалтгаан гэж үзсэн байна. Иймд тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлж худалдан авах өртөгийг нэмэгдүүлсэнээр тамхины хэрэглээ тодорхой хувиар буурах боломжтой гэж үзэж байна.
3. “Тамхины хяналтын тухай хууль”- д онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдэх эрүүл мэндийг дэмжих сан байгуулж, сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай санд төвлөрүүлэн тамхитай тэмцэх үйл ажиллагааны санхүүжүүлтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгохоор заасан байдаг. Энэ заалтын хэрэгжилтэнд зохих хууль эрхийн байгууллагууд хяналт тавин ажиллах. Жилд 1-2 удаа төв замын хөдөлгөөнийг хаан нийтийн эрүүл мэндийн өдрийг зохион байгуулдаг болсон, энэ өдөр олон нийтэд зориулсан тамхины эсрэг сурталчилгааны ажлын хамтад нь зохион байгуулдаг болох.
4. Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг архи, тамхины сурталчилгаа хийх нь их байдаг. Үүний эсрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг эрүүл зан үйлийг олон нийтэд сурталчилах, хүүхэд залуучуудад зөв үнэт зүйлсийг хэвшихэд нь ач холбогдол бүхий нэвтрүүлэгийн цагийг хуулинд тусгах.

5. Бид, иргэний ардчилсан нийгэмд амьдарч байгаагынхаа хувьд бусдын эрхийг хүндэтгэн үзэх чухал энэ утгаараа тамхины эрсдэлт зан үйлийг өөрчлөхийн тулд механик аргуудыг хэрэглэхээс илүүтэйгээр ухамсар, үл ухамсарлахуйд нь нөлөөллийн үйл ажиллагаа явуулах нь илүү дүнтэй. Хөгжилтэй орнуудын туршлагаас харахад тамхи татахад зориулсан байр, объектууд байх ба түүнийхээ хажууд тамхи худалдан авах автомат төхөөрөмж байдаг. Үүнийг хэрэгжүүлснээр тамхины хэрэглээг хянах, иргэд ч бусдад шаардлага тавих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

#### **НОМ ЗҮЙ**

- [1] Австралийн эрүүл мэнд нийгмийн хамгаалалын институт, 1998
- [2] ДЭМБ-ын тайлан мэдээ, 2005 он
- [3] ДЭМБ-ын ТХСК. 2005 он
- [4] Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо, НҮБХС, УБ, 2008
- [5] Монгол улсын үндэсний бодлогыг Тамхины хяналтын суурь конвенцтэй харьцуулсан судалгааны дүн. [http://www.forum.mn/res\\_mat/TobaccoReport\\_mn.pdf](http://www.forum.mn/res_mat/TobaccoReport_mn.pdf)
- [6] Нөлөөллийн ажлын цуврал арга зүй “Нөлөөллийн ажилд шаардагдах ур чадварууд”, Нийгмийн хөгжлийн төв, УБ, 2006
- [7] Нөлөөллийн ажлын цуврал арга зүй “Нөлөөллийн төрөл хэлбэрүүд, зарчимч зөвшилцөл ба эсэргүүцэл”, Нийгмийн хөгжлийн төв, УБ, 2006 Эрүүл мэндийн социологи, Виллиам С.Кокерхам, 2012
- [8] Н. Нямдаваа, Ж. Чинбүрэн Элэгний анхдагч өмөнтэй холбоотой хүн амын мэдлэг, хандлага, дадлын судалгаа. УБ. 2003 [www.moh.mn/moh%20db/HealthReports.nsf](http://www.moh.mn/moh%20db/HealthReports.nsf)
- [9] Олон нийтийг идэвхжүүлэх арга зүй, ЭМЯ, JFPR 9115-MON төсөл, УБ, 2012
- [10] Суурь судалгааны тайлан. УБ, 2020. <https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=GenderBasicSurveyReport.pdf&ln=Mn>
- [11] “Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн санал авах практикийн судалгаа” УБ., 2014.